

НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСӨЛ

2024 оны __ дугаар сарын __-ний өдөр

Дугаар __

Улаанбаатар хот

ХОТ ТӨЛӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГА ХАНГААГҮЙ ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨД НОГДУУЛАХ
АЛБАН ТАТВАРЫН ХЭМЖЭЭГ 1 ХҮРТЭЛ ХУВИАР НЭМЭГДҮҮЛЭН ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын Засаг захиргааны нэгж түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.10 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Монгол Улсын Нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэг, Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэг, Хот байгуулалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.6.3 дахь заалт, 12.8 дахь хэсэг, Татварын ерөнхий хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Хот төлөвлөлтийн шаардлага хангаагүй үл хөдлөх эд хөрөнгөд ногдуулах албан татварын хэмжээг 1 хүртэл хувиар нэмэгдүүлэн тогтоосугай.

2.Тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Х.Нямбаатар)-т даалгасугай.

ДАРГА

Ж.БАТБАЯСГАЛАН

ҮНДЭСЛЭЛ:

МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬ

-35 дугаар зүйлийн 35.1.10 дахь заалт “Хуулиар тогтоосон хязгаарын хүрээнд албан татвар, төлбөр, хураамжийн хувь хэмжээг тогтоох;”

-48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хэлэлцсэн асуудлаар тогтоол гаргах бөгөөд түүнийг тухайн Хурлын хуралдаанд оролцсон төлөөлөгчдийн, баг, хорооны Хурлын хуралдаанд оролцсон иргэдийн олонхын саналаар батална.”

МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛ УЛААНБААТАР ХОТЫН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ

-16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэг “Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь татварын хууль тогтоомжоор эрх олгож, тогтоосон хязгаарын хүрээнд албан татвар, төлбөр, хураамжийн хувь хэмжээг тогтооно.”

ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬ

-6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэг “Хот байгуулалтын тухай хуулийн 12.6.3, 12.8-д заасан цэцэрлэг, ногоон байгууламж, авто зогсоолын шаардлага хангаагүй үл хөдлөх эд хөрөнгөд ногдуулах албан татварын хувь, хэмжээг аймаг нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал энэ хуулийн 6.1-д заасны дагуу тогтоосон хувь, хэмжээг 1 хүртэл хувиар нэмэгдүүлэн тогтоож болно.”

ХОТ БАЙГУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬ

-12 дугаар зүйлийн 12.6.3 дахь заалт “Төлөвлөгөөнд хамруулсан нийт газар нутгийн болон барилга барих зориулалтаар олгосон газрын нийт талбайн 20-оос доошгүй хувь нь цэцэрлэг, ногоон байгууламж, 20-оос доошгүй хувь нь авто зогсоол байна. Хог хаягдлыг цуглуулах, ангилан ялгах, тээвэрлэх зориулалт бүхий талбайтай байна.”

-12 дугаар зүйлийн 12.8 дахь хэсэг “60 хувиас илүүгүй буюу төлөвлөгөөнд хамруулсан нийт газар нутгийн болон барилга барих зориулалтаар олгосон газрын нийт талбайн 20-оос доошгүй хувь нь цэцэрлэг, ногоон байгууламж, 20-оос доошгүй хувь нь авто зогсоол;”

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬ

-8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг “Татварын хувь хэмжээг Улсын Их Хурал, түүний эрх олгосноор Засгийн газар болон аймаг нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, хотын Зөвлөл хууль тогтоомжийн дагуу тус тус тогтооно.”